

CAREC эрчим хүчний салбарын ажлын төлөвлөгөө: Хэрэгжилтийн явц

2015 онд зохион байгуулагдах арга хэмжээг төлөвлөх дээд
хэмжээний уулзалт
2015 оны 1 дүгээр сарын 29 өдөр
Улаанбаатар хот, Монгол улс

Лин Лү, Эрчим хүчний
мэргэжилтэн
Азийн Хөгжлийн Банк
llu@adb.org



Гол үйл явдлууд

Эрчим хүчний салбарын зохицуулах хорооны (ESCC) уулзалт 2014 онд 2 удаа зохион байгуулагдсан :

- 17 дахь удаагийн CAREC-ESCC хурал 2014.4.2-3, Бишкек, Кыргыз**
- 18 дахь удаагийн CAREC-ESCC хурал 2014.9.4-5, Бээжин, БНХАУ**



Гол үйл явдлууд (2)

Эрчим хүчний салбарын 2013-2015 оны ажлын төлөвлөгөөний явц

Элемент	Явц	Дараагийн алхамууд
Element 1: Төв Ази– Өмнөд Азийг холбосон эрчим хүчний коридор хөгжүүлэх	CASA-1000 (ДБ) – ДБ-наас CASA 1000 төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн явцын талаар тайлагнасан. TUTAP (АХБ) – АХБ Афганистаны мастер төлөвлөгөөнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар танилцуулсан ба үүнд CASA 1000 (2014 оны 2-р сард батлагдсан)-гийн Афганистаны ирээдүйн хөгжлийн хэрэгцээнд үзүүлэх нөлөөллийн талаар тусгасан болно.	Энэ хоёр байгууллага төслүүдийн явцын талаарх мэдээллийг ESCC-ийн хурлуудад танилцуулж байх
Элемент 2: Бүс нутгийн эрчим хүчний түгээлт, худалдааны асуудлуудыг	ДБ-ын зүгээс уг бүс нутаг дахь хил дамнасан эрчим хүчний худалдааны нөхцөл байдлын талаар танилцуулж, тодорхой сэдвээр дагнасан ажлын хэсгүүдийг байгуулах, энэ ажлын хэсэгт орж ажиллах салбарын мэргэжилтнүүдийг гишүүн орны ЗГ-ууд тодорхойлж танилцуулах санал гаргасан	ДБ ажлын хэсгүүдийг байгуулах ажлын явцын талаар мэдээлэл өгөх

Гол үйл явдлууд (3)

Эрчим хүчний салбарын 2013-2015 оны ажлын төлөвлөгөөний явц

Элемент	Явц	Дараагийн алхамууд
Элемент 3: Эрчим хүч, усны харилцан уялдааг шийдвэрлэх	Дэлхийн банк Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрчим хүчний эмзэг байдлын судалгааны талаар мэдээлэл өгсөн	Энэ судалгааны үр дүнг хянах эрх бүхий байгууллагуудын тохирох ажилтнуудыг олж тогтоох, улмаар дараагийн уулзалтын үеэр танилцуулах санал гаргасан.
Элемент 4: Эрчим хүчний объект барихад хөрөнгө босгох	Техникийн туслалцааны төслийг 2014 оны 9-р сарын 2 дахь долоо хоногт батлагдана гэж тоцоолон зөвлөхүүдийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байгаа	АХБ дараагийн ESCC-н хуралд ТТ-ны төслийн хэрэгжилтийн статусын талаар мэдээлэл өгөх
Элемент 5: Эрчим хүчний салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүдийн хэрэгжилт	АХБ тэргүүлэх ач холбогдол бүхий төслүүдийн жагсаалтанд орсон өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл өгсөн. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлсэнээр CAREC-ийн биет дэд бүтцийг өргөтгөх, нөхөн сэргээх чиглэлээр хийж буй ажлууд эрчим хүчний аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлтэнд ямар хувь нэмэр оруулж болохыг мөн CAREC-ийн бүс нутагт эрчим хүчний худалдааг нэмэгдүүлэх боломж хэрхэн нэмэгдэхийг	Нарийн бичгийн дарга нарын газраас улс онуудыг одоо байгаа төслүүдийн жагсаалтыг шинэчилж, ESCC-ийн хорооны дараагийн хуралд танилцуулах хүсэлт гаргана.

Гол үйл явдлууд (4)

Эрчим хүчний салбарын 2013-2015 оны ажлын төлөвлөгөөний явц

Элемент	Шинэ мэдээлэл	Дараагийн алхмууд
Элемент 6: Чадавхийг бэхжүүлэх, мэдлэгийн менежмент	АХБ нь 2013-2015 онд хэрэгжүүлэх CAREC-ийн Эрчим хүчний салбарын чадавхийг бэхжүүлэх, мэдлэг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн болон төлөвлөсөн үйл ажиллагааны талаар тайлагнаж, гишүүн улс орнуудыг энэхүү хөтөлбөрт тусгах сургалт, чадавхи бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал, хүсэлтээ танилцуулахыг уриалсан.. АНУ-ын ОУХА RESET төсөл 2014 оны 9-р сард хаагдсанаас хойш 5 жилийн хугацаанд үргэлжлэх 20-25 сая ам.долларын төсөвтэй Эрчим хүчний холбоо төслийн хүрээнд зохион байгуулах худалдан авах ажиллагааны статусын талаарх мэдээллийг хурлын үеэр өгсөн.	Эдгээр хоёр байгууллага энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлуудын талаар ESCC-н дараагийн хурлуудад үргэжлүүлэн мэдээлэл өгнө.

Элемент 6-гийн хүрээнд 2014 онд гүйцэтгэсэн ажлууд

Чадавхи бэхжүүлэх, мэдлэг түгээх

- Эрчим хүчний үр өгөөж семинар: Төв болон Баруун Азийн бүс нутаг , 2014 оны 5-р сарын 28-29, Куала Лампур хот, Малайз улс
- Бүс нутгийн эрчим хүчний худалдааны семинар, 2014 оны 9-р сарын 8-9, Манила хот, Филиппин
- Ногоон эрчим хүчний оффистой танилцах аялал, Малайзын Грийнтек корпораци, 2014 оны 5-р сарын 30, Куала Лампур хот, Малайз улс
- Чангпингийн HVDC төсөлтэй танилцах аялал, Сихуй цахилгаан автобус цэнэглэх/зай солих станц, 2014 оны 9-р сарын 5, Бээжин хот, БНХАУ
- Филиппиний Цахилгаанаар хангах бөөний захтай танилцах аялал, 2014 оны 9-р сарын 9, Манила хот, Филиппин улс

CAREC-ийн вэб хуудас дахь эрчим хүчний талаарх цонхыг сайжруулсан

- Эрчим хүчний талаарх хуудас ба ESCC-ийн салбар хариуцсан зохицуулагчдын мэдээллийг шинэчилсэн



2015 онд төлөвлөсөн ажлууд

ESCC-ийн хурлууд

- ESCC-ийн 19-р хурал, 2015 оны 4-р сарын 6-7, Улаанбаатар хот, Монгол улс
- ESCC-ийн 20-р хурал болон стади тур болон мэдлэг түгээх үйл ажиллагаа, 2015 оны 9-р сарын 7-8, Улаанбаатар хот, Монгол улс

ESCC-с зохион байгуулах чадавхыг бэхжүүлэх, мэдлэг түгээх үйл ажиллагаа

- Чадавхыг бэхжүүлэх сургалт, (сэдэв, байршил хараахан тогтоогүй) 2015 оны 6-р сарын 8-10

EAEN-ё зохион байгуулах чадавхыг бэхжүүлэх, мэдлэг түгээх үйл ажиллагаа

- Хүлэмжийн хий бага ялгаруулдаг дэвшилтэт нүүрний технологи, 2015 оны 6-р сарын 4-5, Бээжин хот, БНХАУ



Баярлалаа!

